



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 07 сарын 17 өдөр

Дугаар 4/290

Мөрөн сум

Газар эзэмших эрхийг дуусгавар болгож,
нийтийн эзэмшилд шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.2, 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2, 39 дүгээр зүйлийн 39.1.3, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2, 43 дугаар зүйлийн 43.1, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн ээлжит бус XVII хуралдааны 09 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Хөвсгөл ус суваг” ХХК (РД:4140265)-аас ирүүлсэн хүсэлтийг дагуу хавсралтад заасан 5 нэгж талбарын 5129м² газрыг нийтийн эзэмшилд шилжүүлсүгэй.

2. Уг захирамжаар газар эзэмшиж байсан “Хөвсгөл ус суваг” ХХК (4140265)-ны газар эзэмших эрхийн гэрчилгээнүүдийг хүчингүй болгож газар эзэмшигчийн мэдээллийн сангаас хасалт хийхийг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Б.Ганзориг), Улсын бүртгэлийн хэлтсийн дарга (Б.Мөнгөнзул) нарт зөвшөөрсүгэй.


3. Аймгийн Засаг даргын захирамжийг эс зөвшөөрвөл уг шийдвэрийг мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор аймгийн Засаг даргад гомдол гаргах эрхтэй болохыг дурьдсугай.

4. Захиргааны актыг ажлын 5 хоногийн дотор эрх, ашиг сонирхол хөндөгдөж буй этгээдэд мэдэгдэж, баримтжуулсан захиргааны актыг хувийн хэрэгт бүрдүүлэлт хийж ажиллахыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Б.Ганзориг)-д үүрэг болгосугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль эрх зүйн хэлтэс (М.Алтаншагай)-д үүрэг болгосугай.

ДАРГА

П.ЛХАГВАЖАВ



ГАЗАР ЭЗЭМШҮҮЛЭХ ЭРХИЙГ ХҮЧИНГҮЙ БОЛГОЖ, НИЙТИЙН ЭЗЭМШИЛД ШИЛГЖҮҮЛСЭН
АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ЖАГСАЛТ

Аймгийн Засаг даргын 2023 оны
07 дугаар сарын 17-ны өдрийн
А/З.20 дүгээр захирамжийн хавсралт

№	Аж ахуйн нэгж, байгууллагын нэр, регистр	Нэгж талбарын дугаар	Газрын зориулалт	Газрын байршил, хаяг	Газрын хэмжээ /м2/	Хүчингүй болгож буй захирамжийн дугаар	Тайлбар
1	"Хөвсгөл ус суваг" ХХК (РД:4140265)	6712015753	5-8 давхар нийтийн орон сууц	8-р баг Алаг 36 байрны баруун талд	666	Аймгийн Засаг даргын 2020.02.10-ны өдрийн А/64 дүгээр захирамжийн хавсралтын 15 дахь заалт	Аймгийн ИТХ-ын 2022 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн ээлжит бус ХҮИ хуралдааны 09 дүгээр тогтоолын хавсралтын 5 дахь заалт
2	"Хөвсгөл ус суваг" ХХК (РД:4140265)	6712015754	Тоглоомын талбай	8-р баг Алаг 36 байрны баруун талд	275	Аймгийн Засаг даргын 2020.02.10-ны өдрийн А/64 дүгээр захирамжийн хавсралтын 14 дэх заалт	Аймгийн ИТХ-ын 2022 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн ээлжит бус ХҮИ хуралдааны 09 дүгээр тогтоолын хавсралтын 6 дахь заалт
3	"Хөвсгөл ус суваг" ХХК (РД:4140265)	6712015756	Авто тээврийн хэрэгслийн зогсоолын талбай	8-р баг Алаг 36 байрны баруун талд	852	Аймгийн Засаг даргын 2020.02.10-ны өдрийн А/64 дүгээр захирамжийн хавсралтын 12 дахь заалт	Аймгийн ИТХ-ын 2022 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн ээлжит бус ХҮИ хуралдааны 09 дүгээр тогтоолын хавсралтын 4 дэх заалт
4	"Хөвсгөл ус суваг" ХХК (РД:4140265)	6712008761	Дэд бүтцийн байгууллага	8-р баг 2 дугаар сургуулийн баруун талд	3040	Аймгийн Засаг даргын 2013.09.23-ны өдрийн А/229 дүгээр захирамжийн хавсралтын 10 дахь заалт	Аймгийн ИТХ-ын 2022 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн ээлжит бус ХҮИ хуралдааны 09 дүгээр тогтоолын хавсралтын 7 дэх заалт
5	"Хөвсгөл ус суваг" ХХК (РД:4140265)	6712015755	Нийтийн эзэмшлийн ногоон байгууламж, цэцэрлэгжүүлж, зүлэгжүүлсэн талбай	8-р баг Алаг 36 байрны баруун талд	296	Аймгийн Засаг даргын 2020.02.10-ны өдрийн А/64 дүгээр захирамжийн хавсралтын 13 дахь заалт	Аймгийн ИТХ-ын 2022 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн ээлжит бус ХҮИ хуралдааны 09 дүгээр тогтоолын хавсралтын 2 дахь заалт

Нийт газрын хэмжээ: 5129м²

-----000-----

[Signature]